



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ширнэнбаньдын АДЬШАА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-61-40, Факс: 32-70-16  
E-mail: adishaash@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023.01.10 № УХХ-03/183

тнай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Уг хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Ш. АДЬШАА



000026



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Ширнэнбаньдын АДЬШАА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-61-40, Факс: 32-70-16  
E-mail: adishaash@parliament.mn  
http://www.parliament.mn

2022.12.28 № ЧУР-03/12557

тнай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх,  
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Уг хуулийн төслийг хянан үзэж Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.Өлзийсайхан ТАНАА

  
Ш. АДЬШАА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ширнэнбаньдын АДЬШАА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-61-40, Факс: 32-70-16  
E-mail: adishaash@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2022.11.14 № ЧИХ-03/10819  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар хүргүүлж байна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, санал, дүгнэлтээ ирүүлнэ ўу.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг хавсаргав.

Хавсралт<sup>6</sup> хуудас.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Ш.АДЬШАА

000965



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ш.АДЬШАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023. 01. 03 № XIT/ 30  
танай -ны №-т

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт  
оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг  
хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт .1. хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000225001177

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлд:

“ХҮИХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаагийн санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь үндэслэлээр дэмжих боломжгүй байгааг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдөр эцэслэн баталсан. Энэхүү хуулийн үзэл баримтлалд “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар татварын бааз сууриа тэлж, улсын төсвийн орлогыг өсгөөд зогсохгүй хуурамч шатахууны үйлдвэрлэлийг хязгаарлаж, иргэдээ олон тэрбум төгрөгийн өрөнд оруулахгүй, тэдний эрх ашгийг хамгаалах арга хэрэгсэл болох юм” гэж тодорхойлсон байдаг. Гэвч газрын тосны дайвар бүтээгдэхүүнд онцгой албан татвар тогтоосноор энэ төрлийн бүтээгдэхүүний импорт зогсож, төсвийн орлого огт нэмэгдээгүй бөгөөд дотоодод газрын тосны бүтээгдэхүүн дахин нэрэх, үйлдвэрлэх үйл ажиллагаа үндсэндээ зогссон байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд “дотоодод үйлдвэрлэсэн түлшийг олон улсын итгэмжлэгдсэн лабораториор шалгуулсан дүгнэлтийг үндэслэн чанарын зохих шаардлага хангасан тохиолдолд зах зээлд нийлүүлэгддэг байна” гэж дурдсан үндэслэл нь салбарын хэмжээнд өнөөг хүртэл шийдэгдээгүй, нөхцөл байдал хэвээр байна.

Иймд газрын тосны дайвар бүтээгдэхүүнээр дотоодод түлш үйлдвэрлэх, эсхүл үйлдвэрлэхийг зогсох эсэх, бүтээгдэхүүний чанар, стандартын шаардлага хангуулах асуудал нь зөвхөн татварын бодлогоор бус газрын тосны бүтээгдэхүүний бодлого, зохицуулалтаар шийдвэрлэх зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, газрын тосны дайвар бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татвараас чөлөөлөх тохиолдолд үүсэх үр дагаврыг тооцоолох шаардлагатай.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Ш.АДЬШАА**

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Онцгой албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, мөн оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд нийт 14 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2011 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-д нийцүүлэн үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр бий болгох, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг бүрдүүлэх, хувийн хэвшлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газрын 2012 оны 112 дугаар тогтоолоор импортын автобензин, дизелийн түлш үйлдвэрлэх түүхий эдийн гаалийн албан татвар “0” хувь, дотоодод үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвар “0” хувьтай байхаар тус тус тогтоосон ба тус тогтоолыг хэрэгжүүлэх хугацаа дууссан.

Засгийн газрын 2018 оны 06 дугаар 06-ны өдрийн 169 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)”-ын 2.3.2-т “Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын таатай бодлогоор дэмжих” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно” гэж, мөн 4.2.16-д “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химиийн үйлдвэр барьж байгуулна” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.2-т “Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн, мөн өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.14-т “Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно” гэж заасан.

**1.2.Практик шаардлага**

2015-2021 онд 22 импортлогч аж ахуйн нэгж, байгууллага нийт 846,9 мянган тонн үйлдвэрийн зориулалттай газрын тосны бүтээгдэхүүн импортлон гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварт 171,8 тэрбум төгрөг төлсөн байна.

Энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн шатахууны бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, Байгаль орчин, аялал жуулчлалын яам химиин бодис импортлох, ашиглах зөвшөөрлийг тус тус олгож байна. Тус зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсын хилээр дээрх нэр бүхий нефтийн бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрэх бүрт вагон тус бүрээс гаалийн болон НӨАТ-ыг төлж барагдуулсан тохиолдолд барааг олгодог байна.

Өөрөөр хэлбэл, холбогдох эрх бүхий байгууллага тухайн бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх болон газрын тосны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгжүүдэд олгож, хувийн хэвшил эрсдэлээ хариуцан өөрийн санхүүжилтээр бүтээгдэхүүнийг импортлох, татвар төлөх, тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах терминал, жижиг оврын үйлдвэр байгуулж орон нутагт ажлын байр бий болгож, олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн хэрэглээнд нийлүүлж байна.

Монгол Улсад анх удаа 2001 онд жилд 50 мянган тонн хийн конденсат (газрын тос) боловсруулах /СМП-50 модуль/ байгууламж бүхий бага хүчин чадлын үйлдвэр байгуулагдаж, ажиллаж эхэлсэн.

Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрийн аргаар дахин нэрж /СМП-50 модуль/-аар оруулж нэмэлт бүтээгдэхүүн, тогтвортжуулагч, цетан ёсгөгч, шингээгчид суурилсан хүхэргүйжүүлэх дамжлагаар дамжин боловсруулалт хийгдсэнээр 60 хувийн гарцтай эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж байна. Энэ нь газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн 30 орчим хувийг бүрдүүлсэн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн болж байна.

Дотоодод үйлдвэрлэсэн түлшийг олон улсын итгэмжлэгдсэн лабораториор шалгуулсан дүгнэлтийг үндэслэн чанарын зохих шаардлага хангасан тохиолдолд зах зээлд нийлүүлдэг байна. Улмаар борлуулалтын дийлэнхийг уул уурхай, газар тариалан, барилгын салбарын үйл ажиллагаа эрхэлдэг 38 харилцагч аж ахуйн нэгжид бөөний үнээр 60-120 хоногийн барьцаагүй эргэн төлөлтийн нөхцөлөөр нийлүүлж, борлуулалтын орлогоос ашгийн татварыг төлж байна. Сүүлийн 3 жилд энэ аргаар зөвхөн дизелийн түлш үйлдвэрлэсэн бөгөөд бүтээгдэхүүнийг жижиглэнгээр буюу шатахуун түгээх газруудад борлуулдаггүй байна. Энэ хугацаанд харилцагч аж ахуйн нэгжүүд өнөөдрийн байдлаар үйлдвэрийн түлшний үнэтэй харьцуулахад 31,6 тэрбумын үнийн зөрүүний хэмнэлт хийсэн байна. Өөрөөр хэлбэл, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн түүхий эдэд ийнхүү онцгой татвар ногдуулснаар үйлдвэрлэлийн зардал өсөж, гарах эцсийн бүтээгдэхүүний үнэ нь импортолгодж буй газрын тосны бүтээгдэхүүнтэй харьцуулахад хэт өндөр болгож, үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг хязгаарлаж байна.

Өнөөгийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээнийхээ 95 ба түүнээс дээш хувийг импортоор хангадаг. Стратегийн чухал ач холбогдолтой энэхүү бүтээгдэхүүний хувьд Оросын Холбооны Улсаас бүрэн хараат байгаа нь манай орны эдийн засгийн аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд газрын тосны үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа газрын тосны дайвар бүтээгдэхүүнд хамаарах керосин, алкалит, хүнд фракцийн дизелийн түлш, нафта-д онцгой албан татвараас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

## **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Газрын тосны үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа газрын тосны дайвар бүтээгдэхүүнд керосин, алкалит, хүнд фракцийн дизелийн түлш, нафта-д онцгой албан татвар ногдуулахгүй байх зохицуулалтыг төсөлд тусгана.

**Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар гарагчийн бөгөөд газрын тосны үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцөл бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал**

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

-----ооо-----

## ТАНИЛЦУУЛГА

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Онцгой албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, мөн оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд нийт 14 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2011 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-д нийцүүлэн үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр бий болгох, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг бүрдүүлэх, хувийн хэвшлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газрын 2012 оны 112 дугаар тогтоолоор импортын автобензин, дизелийн түлш үйлдвэрлэх түүхий эдийн гаалийн албан татвар “0” хувь, дотоодод үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвар “0” хувьтай байхаар тус тус тогтоосон ба тус тогтоолыг хэрэгжүүлэх хугацаа дууссан.

Засгийн газрын 2018 оны 06 дугаар 06-ны өдрийн 169 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)”-ын 2.3.2-т “Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын таатай бодлогоор дэмжих” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно” гэж, мөн 4.2.16-д “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химиийн үйлдвэр барьж байгуулна” гэж тус тус заасныг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2015-2021 онд 22 импортлогч аж ахуйн нэгж, байгууллага нийт 846,9 мянган тонн үйлдвэрийн зориулалттай газрын тосны бүтээгдэхүүн импортлон гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварт 171,8 тэрбум төгрөг төлсөн байна.

Энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн шатахууны бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, Байгаль орчин, аялал жуулчлалын яам химиийн бодис импортлох, ашиглах зөвшөөрлийг тус тус олгож байна. Тус зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсын хилээр дээрх нэр бүхий нефтийн бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрэх бүрт вагон тус бүрээс гаалийн болон НӨАТ-ыг төлж барагдуулсан тохиолдолд барааг олгодог байна.

Өөрөөр хэлбэл, холбогдох эрх бүхий байгууллага тухайн бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх болон газрын тосны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгжүүдэд олгож, хувийн хэвшил эрсдэлээ хариуцан өөрийн санхүүжилтээр бүтээгдэхүүнийг импортлох, татвар төлөх, тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах терминал, жижиг оврын үйлдвэр байгуулж орон нутагт ажлын байр бий болгож, олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн хэрэглээнд нийлүүлж байна.

Монгол Улсад анх удаа 2001 онд жилд 50 мянган тонн хийн конденсат (газрын тос) боловсруулах /СМП-50 модуль/ байгууламж бүхий бага хүчин чадлын үйлдвэр байгуулагдаж, ажиллаж эхэлсэн.

Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрийн аргаар дахин нэрж /СМП-50 модуль/-аар оруулж нэмэлт бүтээгдэхүүн, тогтвортжуулагч, цетан өсгөгч, шингээгчид суурилсан хүхэргүйжүүлэх дамжлагаар дамжин боловсруулалт хийгдсэнээр 60 хувийн гарцтай эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж байна. Энэ нь газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн 30 орчим хувийг бүрдүүлсэн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн болж байна.

Дотоодод үйлдвэрлэсэн түлшийг олон улсын итгэмжлэгдсэн лабораториор шалгуулсан дүгнэлтийг үндэслэн чанарын зохих шаардлага хангасан тохиолдолд зах зээлд нийлүүлдэг байна. Улмаар борлуулалтын дийлэнхийг уул уурхай, газар тариалан, барилгын салбарын үйл ажиллагаа эрхэлдэг 38 харилцагч аж ахуйн нэгжид бөөний үнээр 60-120 хоногийн барьцаагүй өргэн төлөлтийн нөхцөлөөр нийлүүлж, борлуулалтын орлогоос ашгийн татварыг төлж байна. Сүүлийн 3 жилд энэ аргаар зөвхөн дизелийн тулш үйлдвэрлэсэн бөгөөд бүтээгдэхүүнийг жижиглэнгээр буюу шатахуун түгээх газруудад борлуулдаггүй байна. Энэ хугацаанд харилцагч аж ахуйн нэгжүүд өнөөдрийн байдлаар үйлдвэрийн түлшний үнэтэй харьцуулахад 31,6 тэрбумын үнийн зөрүүний хэмнэлт хийсэн байна. Өөрөөр хэлбэл, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн түүхий эдэд ийнхүү онцгой татвар ногдуулснаар үйлдвэрлэлийн зардал өсөж, гарах эцсийн бүтээгдэхүүний үнэ нь импортлогдож буй газрын тосны бүтээгдэхүүнтэй харьцуулахад хэт өндөр болгож, үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг хязгаарлаж байна.

Өнөөгийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээнийхээ 95 ба түүнээс дээш хувийг импортоор хангадаг. Стратегийн чухал ач холбогдолтой энэхүү бүтээгдэхүүний хувьд Оросын Холбооны Улсаас бүрэн хараат байгаа нь манай орны эдийн засгийн аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд Газрын тосны үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа газрын тосны дайвар бүтээгдэхүүнд керосин, алкалит, хунд фракцийн дизелийн тулш, нафта-д онцгой албан татвар ногдуулахгүй байх зохицуулалтыг төсөлд тусгасан бөгөөд газрын тосны үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцөл бүрдэх юм.

-----00-----

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “газрын тосны” гэсний өмнө “үйлдвэрт ашиглах зориулалтаар импортлохоос бусад” гэж нэмсүгэй.

Гарын үсэг

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2022 он**

**АГУУЛГА**

**ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

**НЭГ.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН  
БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

**ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН  
БАЙДАЛ**

3.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.2."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

**ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙГ  
АШИГЛАН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

4.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

4.2."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

**ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу гэж заасны дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дун шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн бичвэрийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид "Хуулийн төсөл" гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын<sup>1</sup> 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-г баримтлан доорх үе шаттайгаар хийв. Үүнд:

Нэг.Шалгуур үзүүлэлтийг сонгох

Хоёр.Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох

Гурав.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлттэд тохиорох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

Дөрөв.Үр дүнг үнэлэх,

Тав.Дүгнэлт, зөвлөмж өгөх.

Үр нөлөөний үнэлгээ хийсэн хуулийн төслийн хувилбарыг энэхүү тайланда хавсаргав.

---

<sup>1</sup> Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

## **Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нэлөөний үнэлгээний тайлан**

### **НЭГ.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, СОНГОХ ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан б шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нэлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Ойлгомжтой байдал;
- 3.Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдаж чадсан эсэх болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн бөгөөд түүнд хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний дагуу хуулийн төспөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн бөгөөд хуулийн зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ буюу зохицуулалтыг сонгож авсан болно.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцдог тул энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээг уг тайлангаас тусдаа бие даасан үнэлгээгээр тооцох нь зүйтэй юм.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэх бөгөөд хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль холбогдох бусад хуультай болон хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр сонгов.

### **ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НЭЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

**2.1.”Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгэдэх хуулийн төслийн зохицуулалт:**

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэхээр зарчмын шинжтэй өөрчлөлтийг үнэлэхээр дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

**Хуулийн төслийн үзэл баримтлалд  
тусгасан хэрэгцээ, шаардлага**

**Хуулийн төслийн зохицуулалт**

## **Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан**

Үйлдвэрлэлийн зориулалттай газрын тосны бүтээгдэхүүнийг онцгой албан татварын тухай хуульд хамааруулахгүй байх зохицуулалт	1 дүгээр зүйл.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын "газрын тосны" гэсний өмнө "үйлдвэрт ашиглах зориулалтаар импортлооос бусад" гэж нэмсүгэй.
--	--

### **2.2."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгэдэх хуулийн төслийн зохицуулалт:**

Хуулийн төслийн заалт нь зөвхөн нэг заалтад хамаарах зохицуулалт болно. Хуулийн бусад заалтад уялдан хэрэгжих боломжтой.

### **ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ**

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2	Харилцан уялдаа	Харилцан уялдааг шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

### **3.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд<sup>2</sup> тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлзээ.

Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн түүхий эдэд ийнхүү онцгой татвар ногдуулснаар үйлдвэрлэлийн зардал өсөж, гарах эцсийн бүтээгдэхүүний үнэ нь импортолгож буй газрын тосны бүтээгдэхүүнтэй харьцуулахад хэт өндөр болгож, үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг хязгаарлаж байна. Стратегийн чухал ач холбогдолтой энэхүү бүтээгдэхүүний хувьд Оросын Холбооны Улсаас

## **Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан**

бүрэн хараат байгаа нь манай орны эдийн засгийн аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулж зөвхөн үйлдвэрлэлийн зориулалттайгаас бусад газрын тосны бүтээгдэхүүнд онцгой албан татвар тогтоох тухай хуулийн зохицуулалтыг бий болгохоор тусгасан байна. Иймд хуулийн төсөл нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, зорилтод зарчмын хувьд нийцсэн байна гэж үзлээ.

### **3.3."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгав.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулж зөвхөн үйлдвэрлэлийн зориулалттайгаас бусад газрын тосны бүтээгдэхүүнд онцгой албан татвар тогтоох тухай хуулийн зохицуулалтыг бий болгохоор тусгасан нь Татварын ерөнхий хуульд заасан татварын зөвхөн Улсын Их Хурал хуулиар тогтоож, хөнгөлж, чөлөөлөх зохицуулалт, Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хуулийн төсөл боловсруулах аргачлал", Онцгой албан татварын тухай хуулийн бусад зохицуулалтад уялдаж байна.

### **ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод "Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно" гэж, "Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна" гэж тус тус заасан.

Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн түүхий эдэд ийнхүү онцгой татвар ногдуулснаар үйлдвэрлэлийн зардал өсөж, гарах эцсийн бүтээгдэхүүний үнэ нь импортлогдож буй газрын тосны бүтээгдэхүүнтэй харьцуулахад хэт өндөр болгож, үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг хязгаарлаж байна. Стратегийн чухал ач холбогдолтой энэхүү бүтээгдэхүүний хувьд Оросын Холбооны Улсаас бүрэн хараат байгаа нь манай орны эдийн засгийн аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөлийг бүрдүүлж байгааг өөрчлөх зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулж зөвхөн үйлдвэрт ашиглах зориулалттайгаас бусад газрын тосны бүтээгдэхүүнд онцгой албан татвар тогтоох тухай хуулийн зохицуулалтыг бий болгохоор тусгасан байна.

Ингэхдээ Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын "газрын тосны" гэсний өмнө "үйлдвэрт ашиглах зориулалтаар импортлохоос бусад" гэж нэмэхээр тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, зорилтод зарчмын хувьд нийцсэн байна гэж үзлээ.

Хуулийн төслийн энэхүү зохицуулалт нь Татварын ерөнхий хуульд заасан татварын зөвхөн Улсын Их Хурал хуулиар тогтоож, хөнгөлж, чөлөөлөх зохицуулалт, Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор

**Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан**

---

баталсан Хуулийн төсөл боловсруулах аргачлал, Онцгой албан татварын тухай хуулийн бусад зохицуулалтад нийцэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх, зорилгоор боловсруулсан байх бөгөөд хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага, зорилтыг зарчмын хувьд хангасан байна гэж үзлээ.

---оо---

Хуулийн төслийн 4.1.5 дахь заалттай уялдуулан 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 6 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 10 дахь заалтад өөрчлөлт оруулах нь зүйтэй.

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ  
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**2022 ОН**

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ,  
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтооолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулахтай холбоотой зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлагын талаархи урьдчилан тандан судалгааг хийж гүйцэтгэлээ.

**НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Монгол Улс гаднаас 100 хувь бензин, дизель түлшээ худалдаж авдаг. Үүний 97 орчим хувийг ОХУ-аас, үлдсэн хувийг БНХАУ болон бусад улсаас нийлүүлдэг. Бензиний үнийн асуудал үндсэн гурван хүчин зүйлээс шалтгаалдаг байна. Энэ нь газрын тосны дэлхийн зах зээл дэх баррелийн үнэ, ОХУ-аас манайд сар тутам тогтоодог хил үнэ, валютын ханш юм. Тухайн бүтээгдэхүүнийг худалдаж авахдаа зөвхөн ам.доллараар тооцоо хийдэг учраас валютын ханш нөлөөлдөг байна.

Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын дагуу газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин нь онцгой албан татвар ногдох бараанд хамааруулахаар заасан. Мөн заалтын тайлбар хэсэгт Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн гэдэгт хүнд фракцын дизелийн тулш, нафта, алкилатыг ойлгоно гэж заасан. Тус хуулийг батлахаас өмнө хийгдсэн тандан судалгааны тайлангаас хараад керосин, хийн конденсатын нэрмэл дистиллят, хөнгөн фракцын бензин буюу нафта... зэрэг газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн болох бодисуудыг шатахуунтай найруулаад зах зээлийн үнээс хямдаар зах зээлд нийлүүлж байна. Найруулсан шатахуун нь машины бензин насос, явах эд ангийг маш богино хугацаанд эвдэж иргэдэд хохирол учруулж байгаа, Мөн ийм үйл ажиллагаа явуулж борлуулсан бүтээгдэхүүнийхээ тоо хэмжээг өсгөж буй компаниуд дээрх бодисуудыг ашигласныхаа төлөө улсад нэг ч төгрөгийн татвар төлөхтүй байгаа асуудлыг мөн нэг мөр цэгцлэхийн зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.<sup>1</sup> гэсэн байдаг. Асуудлыг үүсгэж байгаа дээрх шалтгааныг газрын тос боловсруулах талаар хууль тогтоомжкоор тавьсан шаардлагыг хангуулах, олон улсын болон үндэсний стандарт, төрийн хяналт шалгалтаар хяналт тавьж ажиллах бүрэн боломжтой билээ. Түүнчлэн зөвхөн тодорхой бүтээгдэхүүний татварын орлогыг нэмэгдүүлэх нь төрийн үйл ажиллагааны зорилго байх боломжгүй бөгөөд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих, зардлыг бууруулах замаар төсөвт илүү үр өгөөжтэй байдлаар нөлөөлөх боломж бий.

2015-2021 онд 22 импортлогч аж ахуйн нэгж, байгууллага нийт 846,9 мянган тонн үйлдвэрийн зориулалттай газрын тосны бүтээгдэхүүн импортлон гаалийн болон нэмэгдсэн өртийн албан татварт 171,8 тэрбум төгрөг төлсөн байна.

<sup>1</sup> <https://forum.parliament.mn/projects/10854>

Хамрах хугацаа	Анаилалтын тоо хэмжээ /кг/	Гааль /төв/	Онцгой /төв/	НӨАТ /төв/	Нийт татварын дүн /төв/
2021.08.01-2021.12.31	14,651,182.00	991,228,557.73	4,175,586,870.00	2,499,138,658.26	7,665,954,085.99
2022.01.01-2022.12.27	43,473,969.45	5,631,238,312.35	12,389,875,238.25	13,064,587,979.76	31,085,701,530.36
<b>Нийт дүн</b>	<b>58,125,151.45</b>	<b>6,622,466,870.08</b>	<b>16,565,462,108.25</b>	<b>15,563,726,638.02</b>	<b>38,751,655,816.35</b>

Онцгой албан татварын тухай хуулийн 4.1.5 дахь заалтын батлагдсан 2021.08.01-нээс хойшхи хугацаанд нийт 6 аж ахуйн нэгж импорт хийсэн байна.

## Хүснэгт<sup>2</sup>

Энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн шатахууны бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, Байгаль орчин, аялал жуулчлалын яам химийн бодис импортлох, ашиглах зөвшөөрлийг тус тус олгож байна. Тус зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсын хилээр дээрх нэр бүхий нефтийн бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрэх бүрт вагон тус бүрээс гаалийн болон НӨАТ-ыг төлж барагдуулсан тохиолдолд барааг олгодог байна.

Өөрөөр хэлбэл, холбогдох эрх бүхий байгууллага тухайн бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх болон газрын тосны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгжүүдэд олгож, хувийн хэвшил эрсдэлээ хариуцан өөрийн санхүүжилтээр бүтээгдэхүүнийг импортлох, татвар төлөх, тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах терминал, жижиг оврын үйлдвэр байгуулж орон нутагт ажлын байр бий болгож, олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн хэрэглээнд нийлүүлж байна.

Монгол Улсад анх удаа 2001 онд жилд 50 мянган тонн хийн конденсат (газрын тос) боловсруулах /СМП-50 модуль/ байгууламж бүхий бага хучин чадлын үйлдвэр байгуулагдаж, ажиллаж эхэлсэн.

Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрийн аргаар дахин нэрж /СМП-50 модуль/-аар оруулж нэмэлт бүтээгдэхүүн, тогтвортжуулагч, цетан өсгөгч, шингээгчид сууринсан хүхэргүйжүүлэх дамжлагаар дамжин боловсруулалт хийгдсэнээр 60 хувийн гарцтай эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж байна. Энэ нь газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн 30 орчим хувийг бүрдүүлсэн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн болж байна.

Дотоодод үйлдвэрлэсэн түлшийг олон улсын итгэмжлэгдсэн лабораториор шалгуулсан дүгнэлтийг үндэслэн чанарын зохих шаардлага хангасан тохиолдолд зах зээлд нийлүүлдэг байна. Улмаар борлуулалтын дийлэнхийг уул уурхай, газар тариалан, барилгын салбарын үйл ажиллагаа эрхэлдэг 38 харилцагч аж ахуйн нэгжид бөөний үнээр 60-120 хоногийн барьцаагүй эргэн төлөлтийн нөхцөлөөр нийлүүлж, борлуулалтын орлогоос ашгийн татварыг төлж байна. Сүүлийн 3 жилд энэ аргаар зөвхөн дизелийн түлш үйлдвэрлэсэн бөгөөд бүтээгдэхүүний жижиглэнгээр буюу шатахуун түгзэх газруудад борлуулдаггүй байна. Энэ хугацаанд харилцагч аж ахуйн нэгжүүд өнөөдрийн байдлаар үйлдвэрийн түлшний үнэтэй харьцуулахад 31,6 тэрбумын үнийн зөрүүний хэмнэлт хийсэн байна. Өөрөөр хэлбэл, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн түүхий эдэд ийнхүү онцгой татвар ногдуулснаар үйлдвэрлэлийн зардал өсөж, гарах эцсийн бүтээгдэхүүний үнэ нь импортлогдож буй газрын тосны бүтээгдэхүүнтэй

<sup>2</sup> Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл 2022.12.31

харьцуулахад хэт өндөр болгож, үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг хязгаарлаж байна.



Нефтийн бүтээгдэхүүний үнэ бүх салбаруудад жигд, хамгийн өндөр хувиар, хамгийн олон салбарын үнийг өсгөх нөлөө үзүүлж буй бөгөөд бусад гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүнтэй харьцуулахад хамгийн өндөр хувиар өсгөхөөр байна. Нийт нөлөөллийг хувийн

жингээр жигнэн тооцоолоход шатахууны үнэ 10%-иар өсөхөд салбаруудын дундаж үнэ 0.92%-иар өсөх ба хэрэглээний бараа, үйлчилгээний үнийг хамгийн ихдээ 3.3%-иар өсгөх нөлөө үзүүлэхээр байна.<sup>3</sup>

Өнөөгийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээнийхээ 95 ба түүнээс дээш хувийг импортоор хангадаг. Стратегийн чухал ач холбогдолтой энэхүү бүтээгдэхүүний хувьд Оросын Холбооны Улсаас бүрэн хараат байгаа нь манай орны эдийн засгийн аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөлийг бүрдүүлж байна.




Хүснэгт<sup>4</sup>

Хүснэгт<sup>5</sup>

<sup>3</sup> [https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Salbar\\_hoorondyn\\_tentsel\\_\\_summary.pdf&ln=Mn](https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Salbar_hoorondyn_tentsel__summary.pdf&ln=Mn)

<sup>4</sup> <https://mrpam.gov.mn/article/94/>

<sup>5</sup> <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Foreign%20trade%202021.pdf&ln=Mn>



Эх үүсвэр: Монголбанк, Гадаад секторын статистикийн мэдээлэл

2021 онд 391.1 сая ам.долларын өртөг бүхий 572.7 мянган тонн авто бензин, 590.1 сая ам.долларын 988.9 мянган тонн дизель тулш тус импортолжээ.

## Хүснэгт<sup>6</sup>

ХҮСНЭГТ 8. ИМПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, сая ам.доллароор

Барааны нэр	Хамжих нийтийн	Тоо хэмжээ		2021 %	Үнийн дундаж		2021 %
		2020	2021		2020	2021	
Дизелийн тулш	мян.т	1 026.9	988.9	- 3.7	432.4	590.1	36.5
Автобензин	мян.т	586.1	572.7	- 2.3	244.7	391.1	59.8
Суудлын автомашин	мян.ш	53.1	55.2	4.1	297.3	385.2	29.5
Ачааны автомашин	мян.ш	21.0	26.5	26.4	269.0	385.2	43.2
Цахилгаан эрчим хүч	сая квт.ц	1 684.9	1 823.1	8.2	141.7	160.2	13.1

+29.2%

Импорт өмнөх оноос 1.5 (29.2%) тэрбум америк доллароор всехэд дизелийн тулшиний импорт 157.7 сая америк доллароор, автобензин 146.4 сая америк доллароор, ачааны автомашин 116.2 сая америк доллароор, суудлын автомашины импорт 87.9 сая америк доллароор тус тус оссон нь голлон наелеежээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2011 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-д нийцүүлэн үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр бий болгох, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг бүрдүүлэх, хувийн хэвшлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газрын 2012 оны 112 дугаар тогтоолоор импортын автобензин, дизелийн тулш үйлдвэрлэх түүхий эдийн гаалийн албан татвар “0” хувь, дотоодод үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн тулшиний онцгой албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвар “0” хувьтай байхаар тус тус тогтоосон ба тус тогтоолыг хэрэгжүүлж байсан туршлага бий.

<sup>6</sup> <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Foreign%20trade%202021.pdf&ln=Mn>

Засгийн газрын 2018 оны 06 дугаар 06-ны өдрийн 169 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)”-ын 2.3.2-т “Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын таатай бодлогоор дэмжих” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно” гэж, мөн 4.2.16-д “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна” гэж тус тус заасныг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд Газрын тосны үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа газрын тосны дайвар бүтээгдэхүүнд керосин, алкалит, хүнд фракцийн дизелийн түлш, нафта-д онцгой албан татвар ногдуулахгүй байх зохицуулалтыг бий болгосноо газрын тосны үндэсний үйлдвэрлэл хөгжих, шатахуунаас шатлгаалсан бараа бүтэгдэхүүний үнийн нөлөөлөл буурах, цаашлаад эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэх юм.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Судалгааны зорилго нь тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд уг асуудлыг зохицуулсан журмыг батлах эрхийг холбогдох хуулиар олгох явдал. Үүний тулд дээрх журмыг дараах байдлаар хуульчлах зорилтыг дэвшүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх хуулийн зохицуулалтыг томьёолох;
- Тус зохицуулалт нь хуулийн бусад заалттай нийцэж буй эсэхийг нягтална;
- Тус асуудлыг зохицуулснаар үүсэх үр дагаврын эрэг, сөрөг талыг тодорхойлно;
- Зөвхөн хуулиар зохицуулж болох эсэхийг нягтлах зэрэг болно.

Монгол Улсын хууль тогтоомж	Хуулийн зохицуулалт
Монгол Улсын Үндсэн хууль	“Монгол Улсын иргэн.....хувийн аж ахуй эрхлэх эрхтэй....” гэж заасан.
Иргэний хууль	хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй.” гэж заасан.
Зөвшөөрлийн тухай	9.1. Эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгоходоо дараахь зарчмыг баримтална: 9.1.2. аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх;
Татварын ерөнхий хууль	5.1. Татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: 5.1.3. шударга байх; 5.1.4. үр ашигтай байх.
Онцгой албан татварын тухай хууль	4 дүгээр зүйл. Онцгой албан татвар ногдох бараа, үйл ажиллагаа 4.1. Дараахь бараанд онцгой албан татвар ногдуулна: 4.1.1. бүх төрлийн согтууруулах ундаа; 4.1.2. бүх төрлийн тамхи; 4.1.3. автобензин, дизелийн түлш;

	<p>4.1.4. суудлын автомашин.</p> <p>4.1.5.газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.</p> <p>Тайлбар: Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн гэдэгт хүнд фракцын дизелийн тулш, нафта, алкилатыг ойлгоно.</p> <p>4.1.Доор дурдсанаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чалеелөх, хүчингүй болгох эрхтэй:</p> <p>4.1.1.хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтвортжуулах;</p> <p>4.1.2.чөлөөт бүсэд мөрдөгдөх татварын тусгай дэглэмийг Чөлөөт бүсийн тухай хуулиар тогтоож, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг татварын холбогдох хуулиар зохицуулах.</p>
Өрсөлдөөний тухай	13.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, эрх олгох, бүртгэл явуулах, төлбөр, <b>хураамж авахыг хориглоно.</b>
Засгийн газрын 2010 оны 14 дүгээр тогтоол	<p>2. Импортоор оруулж байгаа газрын тосны бүтээгдэхүүний гаалийн татварыг 2010 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн "5" хувиар тогтоосугай.</p> <p>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийн эсрэг авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 255 дугаар тогтоол, "Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай" Засгийн газрын 2009 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 365 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай</p>

### **ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛУУДЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 5.1 дүгээр зүйлд зааснаар асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилтыг биелүүлэхэд чиглэсэн хувилбаруудыг тогтооно.

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1 Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Энэ хувилбарын сонгох боломжгүй.	Үр дүн сөрөг
2 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нэлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй .	Үр дүн сөрөг
3 Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нэлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй .	Дангаараа үр дүнд хүрэхгүй
4 Төрөөс санхүүгийн интервенци хийх	Зорилгод хүрэх боломжгүй	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нэлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
5 Захиргааны шийдвэр гаргах	Тодорхой тохиолдолд татвар, хураамжийг 0 байхаар тогтоох боломжтой ч зорилтыг бүрэн хангаж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нэлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй .	Тодорхой үр дүнд хүрнэ.

6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нелөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй
---	--------------------------------------	---------------------------	--	-----------

Өмнө дурдсан дүн шинжилгээнээс харахад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хуулийн дагуу шатахууны үнийг бууруулах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар ямар нэг зохицуулалт шаардлагатай байгаа нь харагдаж байна. Иймээс аргачлалын дагуу “тэг хувилбар” буюу ямар ч арга хэмжээ авахгүй, энэ хэвээр үлдээх боломжгүй байна.

Зохицуулалтын бусад хувилбар болох “хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгаа хийх, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, санхүүгийн интервенци хийх, хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар тодорхой үүргийг гүйцэтгүүлэх” зэрэг зохицуулалтын хувилбарыг сонгох боломжгүй байна. Учир нь хууль эрх зүйн хууль ямар нэгэн зохицуулалт шаардлагатай учраас хэрэгжүүлэгч байгууллага болон зөвшөөрөл хүсэгч этгээдэд тодорхойгүй байдал бий болсон хэвээр байхаар байна.

Харин захиргааны акт батлах замаар шийдвэрлэх буюу Засгийн газрын тогтоолор Тодорхой тохиолдолд татвар, хураамжийг О байхаар тогтоох боломжтой ч зорилгыг бүрэн хангаж чадахгүй. Учир нь Татварын ерөнхий хуулиар татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Улсын Их Хурал зөвхөн хуулиар зохицуулахаар заасан.

Иймд тайлангийн өмнөх хэсэгт үнэлсэн асуудал, шалтгаан нөхцөл үүссэн байдлаас харахад “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” замаар зорилгodoо хүрэх боломжтой нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Татварын ерөнхий хуульд заасны дагуу көвхөн хууль батлх замаар тухайн асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Манай тохиолдлын хувьд тандан судалгаа хийж байгаа асуудлаар зайлшгүй хуулийн төсөл боловсруулсаны үндсэн дээр тулгамдаж байгаа асуудал шийдвэрлэгдэх боломжтой гэдэг нь тогтоогдож байна.

### **ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон 2 хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

- 4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- 4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
- 4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө
- 4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- 4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

### **ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 1)**

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		

1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	байхгүй
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	байхгүй
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Ниицнэ.
	<b>1.2. Оролцоог хангах</b>			
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцо боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	эмзэг бүлэг, цөөнхөд чиглэсэн зохицуулалт байхгүй тул шаардлагагүй.
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Үндэсний үйлдвэрлэл эрхлэгч аж аж ахуйн нэгжүүд
3. Эрх агуулагч	<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Иргэний аж ахуй бизнесээ эрхлэн хөгжүүлэх эрхийг хангах, дэмжлэг <b>үзүүлэх</b>
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Нийцнэ.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хариуцлагын зохицуулалт Зөрчлийн тухай хууль, Татварын ерөнхий хуулиар тодорхой зохицуулалттай байгаа тул энэ хүрээнд шийдвэрлэх боломжтой.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарлах зохицуулалт байхгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарлах зохицуулалт байхгүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Аж ахуйн үйл ажиллагааг эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд хамаарна.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Шаардлага бий болохгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Шаардлага бий болохгүй.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Шаардлага бий болохгүй.

Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд
4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Тусгайлан жендерийн асуудлыг авч үзэх шаардлага байхгүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тэгш боломжтой. Аль нэг хүйсийг дээрд эсхүл доор үзэх зохицуулалт байхгүй болно.

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодод үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгжийг дэмжих зорилготой.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Импортын худалдааг тодорхой хэмжээнд бууруулах, гадаад хуралдааны тэнцэлд нөлөө үзүүлэх зорилготой
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхэс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Нефтийн бүтээгдэхүүний хараат байдал, үнийн хэлбэлзлээс шалтгаалсан эдийн засгийн нөлөөлөл, хэт хамаарлыг бууруулах боломжтой
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хөөрөгдөл бий болгохгүй харин бууруулахад чиглэсэн байна.
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгохгүй харин дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ.
	2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Зах зээлд шинээр монополийг бий болгохгүй.
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Шинээр зардал үүсэхгүй? Харин зардлыг бууруулахад чиглэнэ.
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Шаардлага бий болгохгүй

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Тавихгүй, Өрсөлдөөөнт зохицуулалтын явагдах боломжтой.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Аж нэгжиid дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гаргахгүй. Шинээр үүрэг хүлээхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хязгаарлалт тогтоохгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Оюуны өмчийн эрх хөндсөн зохицуулалт бий болгохгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Дотоодоо шатахуун үйлдвэрлэлийг дэмжих тул нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудалд ахиц дэвшлийг дэмжих боломжтой.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэх хялбар болох нэхцэлийг бүрдүүлнэ.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хэрэглээний үнийн түвшинд зэрэгзэр нөлөөлэх боломжтой.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгоно.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хэрэглэгчдийн эрхэд бүрэн нийцнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Түлшний үнийн бууруулах замаар хувь хүн, гэр бүлийн санхүүд урт хугацаанд зэрэгзэр нөлөөлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ажлын байрыг шууд болон шууд бусаар нэмэгдүүлэхэд чиглэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэхгүй.

	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Түвш, нефтийн салбарт нэлөө үзүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсөвт зардал бий болгохгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага бий болохгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгохгүй.
10.Макро здийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих тул эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нэлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нехцэлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулалтын нехцэлийг сайжруулж, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжинэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Нэмэгдэх нехцэлийг бүрдүүлэхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Нийцнэ.

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НЭЛӨӨ (Хүснэгт 3)

Үзүүлэх үр нэлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Шууд болон шууд бусаар ажлын байр нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхottol бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ийм шаардлага бий болохгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд дэмжлэг болно.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нэлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тусгайлан насны хязгаартай холбогдох нэлөөлөл байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нэлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нэлөө үзүүлэхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нэлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нэлөө үзүүлэхгүй

	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Татвар төлбөрийн ногдуулалт, хураан авалтад нөлөө үзүүлнэ
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас барагтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд серег нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хоолголт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад серег нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.

	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөх боломжтой.
2.Зам тэзвэр, тулш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөх боломжтой
	2.2.Эрчим хүчиний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрлэлийг дэмжих тул эрчим хүчиний хэрэглээг тодорхой хэмжээнд бий болгоно.
	2.3.Эрчим хүчиний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шатахуун нефтийн бүтээгдэхүүн гаргах авах үйлдвэрлэлийг дэмжих тул эрчим хүчиний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх боломжтой.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нэмэгдүүлэхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон үүний ус, цэвэр усны нөөцдөд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Урт хугацаандаа нөлөөлөх боломжтой
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нэмэгдүүлэхгүй
	4.3.Унданы усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй

	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ийм шаардлага бий болохгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохицой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ийм шаардлага бий болохгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ийм шаардлага бий болохгүй

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Онцгой албан татварын тухай хуульд холбогдох зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлагыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу судлан үзэж дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын дагуу газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин нь онцгой албан татвар ногдох бараанд хамааруулахаар заасан. Зөвхөн тодорхой бүтээгдэхүүний татварын орлогыг нэмэгдүүлэх нь төрийн үйл ажилагааны зорилго байх боломжгүй бөгөөд харин дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих, зардлыг бууруулах замаар төсөвт илүү үр өгөөжтэй байдлаар нөлөөлөх боломж бий.

Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн түүхий эдэд ийнхүү онцгой татвар ногдуулснаар үйлдвэрлэлийн зардал өсөж, гарах эцсийн бүтээгдэхүүний үнэ нь импортлогдож буй газрын тосны бүтээгдэхүүнтэй харьцуулахад хэт өндөр болгож, үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг хязгаарлаж байна. Стратегийн чухал ач холбогдолтой энэхүү бүтээгдэхүүний хувьд Оросын Холбооны Улсаас бүрэн хараат байгаа нь манай орны эдийн засгийн аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Түүнчлэн Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих чиглэлээр зорилтууд тусгагдсан. Газрын тосны үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа газрын тосны дайвар бүтээгдэхүүнд керосин, алкалит, хүнд фракцийн дизелийн тулш, нафта-д онцгой албан татвар ногдуулахгүй байх зохицуулалтыг бий болгосноор газрын тосны үндэсний үйлдвэрлэл хөгжих, шатахуунаас шалтгаалсан бараа бүтээгдэхүүний үнийн нөлөөлөл буурах, цаашлаад эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэх ач холбогдолтой байна.

Ийнхүү асуудлыг үүсэж байгаа шалтгааныг арилгахын тулд зохицуулалтын бусад хувилбар болох төрөөс нэг удаагийн арга хэмжээ авах, захиргааны актаар шийдвэрлэх зэрэг арга хэмжээг хэрэглэх боломжгүй байна. Учир нь Татварын ерөнхий хуулиар татварыг бий болгох, татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Улсын Их Хурал зөвхөн хуулиар зохицуулахаар заасан.

Иймд тайлангийн өмнөх хэсэгт үнэлсэн асуудал, шалтгаан нөхцөл үүссэн байдлаас харахад хууль тогтоомжийн төсөл боловсруулах замаар зорилгодоо хүрэх боломжтой нь харагдаж байх тул Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах замаар үйлдвэрлэлийн зориулалттай газрын тосны бүтээгдэхүүнийг онцгой албан татвараас чөлөөлөх боломжтой байна.

---oOo---

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ  
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

УЛААНБААТАР ХОТ  
2022 ОН

## **АГУУЛГА**

### **Нэг.Ерөнхий үндэслэл**

**Хоёр.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:**

- 2.1.иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 2.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.нийт дүнг тооцож гаргах;
- 2.5.хялбарчлах боломжийг шалгах.

**Гурав.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:**

- 3.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.нэг бүрийн зардлыг тооцох;
- 3.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 3.5.хялбарчлах боломжийг шалгах;
- 3.6.нэмэлт зардлыг тооцох.

**Дөрөв.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн тесөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:**

- 4.1.төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 4.2.уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3.гарах зардлыг тооцох;
- 4.4.зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5.хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

## ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

### НЭГ.ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

### ХОЁР.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолоходоо дараахь дарааллыг баримтална. Үүнд:

- иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох
- цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
- тоон үзүүлэлтийг тооцох
- нийт дунг тооцож гаргах
- хялбарчлах боломжийг шалгах

Аргачлалын дагуу иргэнд үүрэг болгосон зохицуулалт буюу хуулиа заавал биелүүлэх ёстой үйл ажиллагааг хуулийн төслөөс олж тогтоох учиртай.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгаснаар хуулийн зорилго нь газрын тосны бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн түүхий эдийн зардлыг бууруулах, эцсийн бүтээгдэхүүний үнийг бууруулах замаар үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг бүрдүүлэх гэж үзэхээр байна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд иргэнд үүрэг болгосон ямар нэг зохицуулалт тусгагдаагүй байх тул дээрх үе шатны ажлыг гүйцэтгэх шаардлагагүй болно.

<sup>1</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

## ГУРАВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мэнгэн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно.

Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
- нэг бүрийн зардлыг тооцох
- тоон үзүүлэлтийг тооцох
- нийт зардлын дүнг тооцож гаргах
- хялбарчлах боломжийг шалгах
- нэмэлт зардлыг тооцох

### Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно. Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачла”-ын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мэнгэн зардлыг тооцно.” гэж заасан.

Хуулийн этгээдэд үүрэг болгосон зохицуулалт тусгагдаагүй байх тул энэ хэсэгт зардлын тооцооопон бodoх шаардлага үүсэхгүй байна. Иймд хуулийн этгээдэд зардал нэмэгдэх боломжгүй харин зардлын бууралт бий болно.

## ДӨРӨВ. УЛСЫН ТӨСӨӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

### 3.2.Хүний нөөцийн хэрэгцээг тооцох

Хуулийн төсөлд төрийн байгууллагад тоорхой хэмжээгээр үүрэг нэмэгдүүлсэн, үүнтэй холбогдуулан тодорхой мэнгэн зардал бий болж болзошгүй зохицуулалт тусгагдсан байх тул төрд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- 4.1.төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;
- 4.2. уг чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3. гарах зардлыг тооцох;
- 4.4. зардлыг нэгтгэн тооцох;

#### 4.5. хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Энэ шатанд төрийн байгууллагын ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд гүйцэтгэх тоо буюу тохиолдлын тоо, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг гаргана..

**Хуулийн төсөл дэх төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг /ажил үйлчилгээ/, түүний агуулгыг тодорхойлбол:**

4.1. Дараахь бараанд онцгой албан татвар ногдуулна:

4.1.5. үйлдвэрт ашиглахаас бусад зориулалтын газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.

Төрийн байгууллагад хүний нөөцийн зардал шинээр бий болгохгүй, мөн мөнгөн зардал шууд бий болгохооргүй байна. Харин улсын төсвийн татварын орлого дээр дурдсан хэмжээгээр нөлөөлөх боломжтой байна.

Энэ хэсэгт харин зарим тоон мэдээллийг харуулбал:

2015-2021 онд 22 импортлогч аж ахуйн нэгж, байгууллага нийт 846,9 мянган тонн үйлдвэрийн зориулалттай газрын тосны бүтээгдэхүүн импортлон гаалийн болон нэмэгдсэн өргтийн албан татварт 171,8 тэрбум төгрөг төлсөн байна. Өөрөөр хэлбэл 22 импортлогч аж ахуйн нэгж, байгууллага нэг жилд дунджаар 24.5 тэрбум төгрөгийг гаалийн болон нэмэгдсэн албан татварт төлсөн байна.

**Газрын тосны дайвар бүтээгдэхүүн, керосиний импортын мэдээ 2021.08.01-2022.12.31**

Хамрах хугацаа	Ангилалтын тоо хэмжээ /кг/	Гааль /төг/	Онцгой /төг/	НӨАТ /төг/	Нийт татварын дүн /төг/
2021.08.01-2021.12.31	14,651,182.00	991,228,557.73	4,175,586,870.00	2,499,138,658.26	7,665,954,085.99
2022.01.01-2022.12.27	43,473,969.45	5,631,238,312.35	12,389,875,238.25	13,064,587,979.76	31,085,701,530.36
<b>Нийт дүн</b>	<b>58,125,151.45</b>	<b>6,622,466,870.08</b>	<b>16,565,462,108.25</b>	<b>15,563,726,638.02</b>	<b>38,751,655,616.35</b>

Онцгой албан татварын тухай хуулийн 4.1.5 дахь заалтын батлагдсан 2021.08.01-нээс хойшхи хугацаанд нийт 6 аж ахуйн нэгж импорт хийсэн байна.<sup>2</sup>

<sup>2</sup> Гаалийн срөнхий газраас ирүүлсэн мэдээлэл 2022.12.31-ний өдөр

## ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>3</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцоход дараах дүгнэлт гарлаа.

Аливаа шинээр батлагдаж байгаа хуулийн төсөл ямар нэг байдлаар тодорхой хэмжээний зардлыг бий болгодог гэж үздэг. Гэхдээ манай тохиолдын хувьд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд иргэнд үүрэг болгосон ямар нэг зохицуулалт тусгагдаагүй байх тул иргэнд ямар нэгэн цаг хугацааны ачаалал үүсэхгүй, мөнгөн зардал бий болох боломжгүй байна.

Түүнчлэн хуулийн этгээдэд үүрэг болгосон, зардал нэмэгдүүлэхээр зохицуулалт тусгагдаагүй байх тул хүний ямар нэгэн мөнгөн зардал үүсэхээргүй байна.

Төрийн байгууллагад хүний нөөцийн зардал шинээр бий болгохгүй, мөн мөнгөн зардал шууд бий болгохооргүй байна. Харин улсын төсвийн татварын орлого дээр дурдсан хэмжээгээр нөлөөлөх боломжтой байна. Гэвч энэ нь татварт төвлөрүүлэх орлогын бууралт болон импортын хэмнэлт гаргасан зөрүү буюу зардал үр өгөөжийн харьцаа эерэг түвшинд байна гэж үзэхээр байна.

---оОо---

---

<sup>3</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн



Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулсан бөгөөд, иргэд олон нийтээс санал авахаар <https://d.parliament.mn/> байршуулсан.

Олон нийтийн зүгээс тусгайлсан санал ирүүлээгүй болно.